



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/166

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а, 29.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 3/03 дугаар төсөв батлах тухай тогтоолын 6 дугаар хавсралтын 5.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хот тохижилтын үйл ажиллагаа эрхлэгч “Шинэ Ховд-Жаргалант ТҮК” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын цалин болон үйл ажиллагааны зардалд 150 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.7 дахь заалтаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

4.“Шинэ Ховд-Жаргалант ТҮК” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын цалин болон үйл ажиллагаанд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/166 Ch
02 1998

Аймгийн Засаг даргын
2021 оны 03 дугаар сарын 29-ний
өдрийн А/166 дугаар захирамжийн
хавсралт

“ШИНЭ ХОВД - ЖАРГАЛАНТ ТҮК” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАРДАЛ

/төгрөгөөр/

д/д	Зардлын нэр		
1	Цалин	23,001,328.0*3сар	69,003,984.0
2	Үйл ажиллагааны бусад зардал	26 998 695 *3сар	80,996,086.0
Нийт зардал			150,000,000.0

-oOo-